



## ОЛОН УЛСЫН СОНГУУЛИЙГ АЖИГЛАХ ХОРОО Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26

### УРЬДЧИЛСАН ҮР ДҮН БА ДҮГНЭЛТИЙН ТАЙЛАН

#### УРЬДЧИЛСАН ДҮГНЭЛТ

Ерөнхийлөгчийн сонгууль өрсөлдөөнтэй, зохион байгуулалт сайтай, сонгуулийн сурталчилгаа богинохон боловч ширүүн болж өнгөрлөө. Эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн байдалд боллоо. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа сунжирч, шүүхэд шилжүүлсэн хэргүүд шийдвэрлэгдэхээр хүлээгдэж байгаа нь нэр дэвшигчдийн талаар тодорхойгүй байдал үүсгэв. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонгуулийн сурталчилгаа өргөн дэлгэр цацагдсан боловч дүн шинжилгээнд суурилсан мэдээллээр дутмаг байлаа. Сонгуулийн байгууллага дунд шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг томилохдоо намын харьяалал харгалзах хандлага байсныг эс тооцвол үр дүнтэй ажилласан. Ажиглахаар очсон санал авах байруудад санал хураалт, тоолох үйл явц эмх журамтай явагдаж байсан хэдий ч СЕХ дөнгөж нэгтгэсэн дүнг мэдээлснээр ил тод байдал зарим талаар алдагдсан.

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулж өгсөн нь ардчилсан сонгууль явуулах хангалттай үндэс суурийг тавьсан байна. ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн зарим санал зөвлөмжүүдийг анхааран авч үзсэн хэдий ч ялангуяа сонгох эрхтэй холбогдох зарим чухал зөвлөмжүүдийг орхигдуулсан хэвээр байна.

Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) нь сонгуулийн бэлтгэл ажлыг сонгууль зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон хуульд заасан хугацаануудад багтаан ажилласан бөгөөд сонгуулийн оролцогч талуудын итгэлийг хүлээсэн. Хуулиар СЕХ нь шаардлагатай гэж үзсэн зохицуулалтыг батлах бүрэн эрхгүй байна. 2016 онд орон нутгийн иргэдийн хурлууд дахь эрх мэдэл шилжсэнээс шалтгаалж, дунд шатны сонгуулийн олон хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тул зарим оролцогч талууд эдгээр хороодын хараат бус байдалд эргэлзэж байсан.

Энэ удаагийн сонгуульд нийт 1,978,298 сонгогч оролцохоор бүртгэгдсэн. Оролцогч талууд нь сонгогчдын бүртгэлийн үнэн зөв, бүх сонгогчийг хамруулсан зэрэгт ерөнхийд нь итгэж байгаагаа илэрхийлэв. Сонгуулийн тухай хуулиар хорих газар ял эдэлж байгаа иргэдийн үйлдсэн гэмт хэргийн хүнд, хөнгөнийг үл харгалзан сонгуульд санал өгөх эрхийг хасч байгаа нь бүх нийтийн сонгуулийн эрх, нэр дэвшүүлэх эрхийн баталгааг сулруулж байгаа бөгөөд ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичиг, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын гэрээ хэлэлцээртэй нийцэхгүй байна.

УИХ-д суудалтай гурван намыг төлөөлсөн гурван нэр дэвшигч энэ удаагийн сонгуульд өрсөлдлөө. Хуулиар бусад нам нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд бие даан нэр дэвшихийг зөвшөөрдөггүй. Ерөнхийдөө нэр дэвшүүлэх талаар тавигдаж буй шаардлагууд нь хэтэрхий хатуу байгаагаас гадна сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна.

20 хоногийн хугацаанд өрнөсөн сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй явагдаж дууссан бөгөөд иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж чадлаа. Гэсэн хэдий ч улс төртэй холбоотой үг хэллэг нь гадныхныг гадуурхсан хэл ярианаас ангид байсангүй. Нэр дэвшигчдийг авилга авсан, бусад хууль бус үйл ажиллагаанд оролцсон гэж буруутгасан хэд хэдэн бичлэг олон нийтэд цацагдсан нь сонгуулийн сурталчилгааны өрнөлд нөлөөлсөн зүйл болов. Төрийн

захиргааны байгууллагын албан ёсны үйл ажиллагаа болон улс төрийн сурталчилгааны хоорондох зааг ялгааг бүдгэрүүлсэн тохиолдлууд ажиглагдав. Сонгуулийн сурталчилгааны хугацаа хэтэрхий богино, мөн хуулиар мөрийн хөтөлбөрүүдийг урьдчилан батлахыг зааж өгсөн зэрэг нь нэр дэвшигчдийг олон нийтэд үзэл санаагаа илэрхийлэх боломжийг нь хязгаарлаж байна.

Сонгуулийн санхүүжилтын талаарх хууль тогтоомж нь нэр дэвшигчдийн тэгш өрсөлдөх эрхийг тодорхой хэмжээнд хангаж өгсөн боловч ил тод байдал, хариуцлагын талаарх зохицуулалтууд дутуу дулимаг, мөн улс төрд буй авилгын асуудлуудыг хамарч чадахгүй байна. Үндэсний аудитын газраас авч буй нэмэлт арга хэмжээнүүд сонгуулийн санхүүжилтын талаарх үнэн бодит мэдээллийг сонгогчдод хангалттай хэмжээнд олгож чадахгүй байгаа нь сонгогчдийн мэдээлэлд үндэслэсэн сонголт хийхэд нь нөлөөлж байна.

Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нь хуульд заасны дагуу нэр дэвшигч тус бүрт үнэ төлбөргүй цагийг олгосон. Арилжааны телевизийн сувгууд улс төрийн намуудаас бэлтгэж өгсөн, эсвэл төлбөртэй сонгуулийн сурталчилгааны материал нэвтрүүлж байв. Олон нийтийн болон арилжааны радио телевизүүд сонгогчдод хараат бус, дүн шинжилгээнд суурилсан мэдээлэл огт хүргээгүй. Хүний нэр төрд халдан гутаах хэргийг сонгуулийн дараа л эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо больж байгаа.

Нийгэм, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудал нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгааны үеэр ч, мөн хэвлэл мэдээллээр ч бараг хөндөгдөөгүй. Хэдий тийм боловч жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх санал санаачилга хоёр нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан байв. Сонгуулийн сурталчилгааны штабуудад олон эмэгтэй ажилтнууд ажиллаж байснаас гадна доод шатны сонгуулийн хороодод эмэгтэйчүүд давамгайлж байв. Гэсэн хэдий ч СЕХ-н дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүй хэмжээнд байна.

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. СЕХ эдгээр иргэдийг санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахын тулд нилээдгүй хүчин чармайлт гаргасны зэрэгцээ хоёр нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлуудыг тусгажээ. Сонгуулийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан хэдий ч санал авах олон байр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байв.

Хууль эрх зүйн хүрээнд бүх ажиглагчдад холбогдох эрхийг хангалттай хэмжээнд олгосон байдаг. Иргэд олон нийтийн ажиглагчид санал авах өдрөөс өмнөх хугацаанд идэвхтэй ажиллаж, сонгуультай холбоотой асуудлуудаар сонгогчдын ойлголт мэдлэгт хувь нэмэр оруулсан. Тухайлбал, сонгуулийн тухай нэвтрүүлэг, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, санал тоолох төөхөрмжийн үнэн зөв байдал зэрэг олон асуудлаар цаг тухайд нь мэдээлэл хийж байлаа. СЕХ нэр дэвшигч дэвшүүлсэн намуудын нийт 17,947 ажиглагчийг бүртгэж үнэмлэх олгосон.

Иргэн сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа хэтэрхий сунжруу байгаа нь хуулиар хамгаалуулах эрхийг хязгаарлаж, хэрэг шүүхээр шийдвэрлэгдэхгүй удах зэрэг нь нэр дэвшигчдийн талаар сонгогчдод эргэлзээ төрүүлж байсан. Сонгуулиас өмнө сонгуулийн байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдлын дунд доод шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүний талаар өргөдөл байсан; Цагдаагийн байгууллагад сонгуулийн сурталчилгаатай холбоотой 500 орчим гомдол ирснээс зурагт самбарыг сүйтгэсэн,

нэр дэвшигчдийг гутаан доромжилсон, мөн санал худалдан авах гэж байна гэх гомдлууд байлаа.

Ажиглалт хийгдсэн ихэнх санал авах байранд сонгууль эмх журамтай явагдаж, сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд санал хураалтыг тогтоосон журмын дагуу ажиллав. Хэдийгээр сонгогчдод саналаа нууцаар өгөхөд зориулсан нууцлалын хавтас өгсөн нь сайшаалтай хэрэг байсан боловч хэд хэдэн санал авах байранд төөрөгдөл үүсэж, саналын нууцлалт нэг түвшинд мөрдөгдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн. СЕХ нь саналын хуудсыг автоматаар тоолсны дараа нэгтгэсэн дүнг шууд дамжуулж эхэлсэн боловч дүнг дүүрэг, хэсгийн хороодын түвшинд задлан нийтлээгүй тул бие даасан хяналт тавих боломжийг хязгаарласан явдал боллоо.

## Оршил

Монгол Улс нь холимог буюу хагас ерөнхийлөгчийн засаглалтай бүгд найрамдах улс бөгөөд ерөнхийлөгч болон УИХ нь өргөн хүрээтэй, зарим тохиолдолд хоорондоо давхардсан эрх мэдэлтэй байдаг. УИХ болон ерөнхийлөгчийн бүрэн эрхийг дахин хуваарилах талаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар олон нийтийн дунд болон парламент дээр яригдаж буй хэлэлцүүлэг нь энэ сонгуулийн нэг содон дүр зураг болов.

2017 оны 1-р сарын 26-ны өдөр парламент (Улсын Их Хурал)-аас ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг 6-р сарын 26-ны өдөр явуулахаар товлов. Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль нь 2016 оны 6-р сарын 29-ний өдөр болсон УИХ-ын сонгууль болон 2016 оны 6, 10-р сард тус тус болсон орон нутгийн хурлын сонгуулийн дараа болж байна. Энэхүү сонгуулийн мөчлөгөөр Монгол ардын нам (МАН) парламентын 76-н суудлын 65-ыг авч улс төрийн давамгайл байдалд очсон төдийгүй ихэнх аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд олонх болсон. Ардчилсан нам (АН) УИХ-д 9 суудал авсан бөгөөд нэг аймагт засаг даргын суудалтай. Монгол ардын хувьсгалт нам (МАХН) нэг суудалтай. Бүрэн эрхийн хугацаа нь дуусч буй Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж нь АН-ыг төлөөлдөг.

Энэ удаагийн сонгууль нь эдийн засгийн хямрал үргэлжилж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт доройтон, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурч, ажилгүйдэл ихэссэн нөхцөл байдалд явагдаж байна. Хоёрдугаар сард Монгол Улс нь Олон улсын валютын сан болон бусад зээлдүүлэгчдээс тусламж авах гэрээг байгуулсан ба ингэснээр шууд төлбөрийн чадваргүй болох эрсдлээ бууруулж, засгийн газар нийгмийн хамгааллын гол хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэх боломжтой болсон билээ. Эдийн засаг удааширч, мөн эдийн засгийн хувьд улам бүр БНХАУ-аас хамааралтай болж байгаа нь популист болон гадныхны эсрэг үзэл санааг өөгшүүлж, сонгуулиас өмнө тогтворгүй орчин нөхцөл үүсэхэд нөлөөлж байна.

## Хууль эрх зүйн хүрээ ба сонгуулийн тогтолцоо

1992 оны Үндсэн хууль (хамгийн сүүлд 2001 онд нэмэлт өөрчлөлт орсон)-иар суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулсан бөгөөд сонгуулийн хууль эрх зүйн хүрээнд ардчилсан сонгууль явуулах хангалттай суурийг тавьж өгсөн байдаг.<sup>1</sup> Суурь хууль тогтоомж дээр нэмэгдээд Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ)-ноос гаргаж буй дүрэм журмууд мөн дагалдаж байна. Гэвч

<sup>1</sup> Ерөнхийлөгчийн сонгуультай холбоотой хууль эрх зүйн хүрээ нь 1992 оны Үндсэн хууль, 2016 онд нэмэлт өөрчлөлт орсон 2015 оны Сонгуулийн тухай хууль (СТХ), 2006 оны Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ), 2011 оны Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль (САСТХ) болон 2005 оны Улс төрийн намын тухай хууль (УТНТХ) зэргээс үндсэндээ бүрдэж байна. Мөн Эрүүгийн хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудын холбогдох заалтууд хамаарна. Монгол Улс нь олон улсын хүний эрхийн чухал гэрээ конвенциудад нэгдэн орсон бөгөөд Үндсэн хуулиараа эдгээр арга хэрэгслийг дотоодын хууль тогтоомжуудад шууд хэрэглэх нөхцлийг бий болгож өгсөн байдаг.

уг хууль тогтоомжоор шаардлагатай гэж үзсэн зохицуулалтаа батлах СЕХ-ны бүрэн эрхийг хязгаарласан байгаа нь сонгуулийн хууль тогтоомжийн уялдаа холбоотой, тууштай хэрэгжилтийг баталгаажуулах арга хэрэгсэлгүй болгож байна.<sup>2</sup>

Сонгуулийн тухай хууль (СТХ) нь 2015 онд батлагдсан бөгөөд сонгуулийн тухай хэд хэдэн хуулийг нэгтгэж, улмаар 2016 оны УИХ-ын сонгуулийн өмнөхөн хоёр удаа нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүдэд ЕАБХАБ/АИХЭГ-аас өмнө нь өгсөн зарим зөвлөмжүүдийг тусгажээ. Тухайлбал нэр төр гутаасан хэргийг эрүүгийн хэрэгт тооцохгүй болгосон (7-р сарын 1-нээс эхэлж мөрдөгдөнө), мөн сонгуулийн хороодын болон шүүхийн хооронд маргаан шийдвэрлэхтэй холбоотой давхардсан журам, заалтууд ямар нэг хэмжээгээр хасагдсан байна. Гэвч ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн амлалтуудтай болон ИУТЭОУП-ын үүрэг хариуцлагатай зөрчилдөж буй заалтууд, ялангуяа сонгох, сонгогдох эрх болон сонгуультай холбоотой маргааныг шийдвэрлэх хуулийн хугацаа хэтэрхий сунжруу байгааг хасахыг зөвлөсөн удаан хүлээгдэж буй зөвлөмжүүдийг орхигдуулсан байна.<sup>3</sup> Цаашлаад СТХ-нд сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхээс өмнө сурталчилгаа явуулах, санал асуулга нийтлэх, хэвлэл мэдээллээр төлбөртэй сурталчилгаа явуулах, сонгогч бүртгэлээс түр хасахтай холбоотой хуулийн хийдэл, хоорондоо зөрчилдсэн заалтууд байна.

Ерөнхийлөгч нь улсын хэмжээнд сонгуулийн нэг тойргоос олонхийн буюу мажоритар тогтолцоо бүхий хоёр шаттай сонгуулиар шууд сонгох эрхийн үндсэн дээр сонгогдоно. Хэрэв нэр дэвшигчдийн аль нь ч санал өгсөн сонгогчдын олонхийн саналыг аваагүй бол анхны санал хураалтаас хойш хоёр долоо хоногийн дотор хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн дунд хоёр дахь санал хураалтыг явуулна.

Хэрэв улсын хэмжээнд сонгуулийн ирц 50 хувиас доош гарвал ирц нь энэ босгоос доош байсан сонгуулийн хэсгүүд дээр нэг долоо хоногийн дотор дахин санал авна. Дахин санал хураахад зөвхөн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн боловч сонгуулийн өдөр саналаа өгөөгүй сонгогчид санал өгнө. Дахин санал хураалтаар өгсөн саналын тоог анхны санал хураалтын тоон дээр нэмнэ. Энэ заалт нь тэгш сонгох болон ялгаварлан гадуурхахгүй байх тухай олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байна.<sup>4</sup>

## Сонгуулийн байгууллага

СЕХ нь есөн гишүүний бүрэлдэхүүн (нэг гишүүн нь эмэгтэй)-тэй байнгын ажиллагаатай байгууллага бөгөөд гишүүд нь зургаан жилийн хугацаатайгаар томилогддог. Сонгуулийн төв байгууллагын тухай хууль (СТБТХ)-иар гишүүдийг үүрэгт ажлаас нь дур мэдэн чөлөөлөхийг

<sup>2</sup> Үндсэн хуулиар Дээд шүүхэд хууль тогтоомжийн талаар албан ёсны тайлбар өгөх эрхийг олгосон байдаг. Хэдийгээр СЕХ-ноос удаа дараа хүсэлт хүлээн авч байсан ч 2012 оноос хойш Дээд шүүх нь үндсэн хуулиар олгогдсон энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна. Дээд шүүхээс ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдээлснээр Шүүхийн тухай хуульд бүрэн эрхийг нь тодорхой болгохоос нааш тус байгууллага хуулийн тайлбар өгөх боломжгүй гэв.

<sup>3</sup> 1990 оны [ЕАБХАБ-ын Копенгагены Баримт бичгийн](#) 7.3 ба 7.5 дахь хэсэгт “насанд хүрсэн иргэдийн нийтээрээ, шууд сонгох эрхийг тогтоож, иргэд “улс төрийн болон төрийн албан тушаал дангаараа болон улс төрийн нам, байгууллагын төлөөллөөр дамжуулан ялгаварлан гадуурхагдалгүй” хаших эрхийг хүндэтгэнэ гэж заажээ.

<sup>4</sup> “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (ИУТЭОУП)-ын 25-р зүйлд шууд сонгох эрхийг хамгаалж өгсөн байдаг. Анхны санал хураалтын өдөр санал өгсөн хэсгийн хороон дээр нь ирц 50 хувиас хэтэрсэн гэсэн үндэслэлээр сонгуулийн эрх бүхий сонгогчдын дахин санал хураалтад оролцож, саналаа өгөх эрхийг нь үгүйсгэсэн мөртлөө адилхан тойрог дээр байгаа бусад сонгогчдод энэ эрхийг олгож байгаа нь оршин суугаа газраар нь ялгаварлан гадуурхаж байгаагаас гадна тэгш сонгох зарчимд харшилж байна.

хориглож өгсөн нь олон улсын сайн туршлагатай нийцэж байна.<sup>5</sup> СЕХ нь ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулах талаар өргөн хүрээтэй үүрэг хариуцлагыг хүлээж байгаа бөгөөд ээлжит сонгуулийг зохион байгуулах цаг хугацааны хуваарь болон хуульд заасан чухал хугацаанд олон үүрэг даалгавруудыг хийж гүйцэтгэлээ.<sup>6</sup> 4-р сараас 6-р сарын хооронд аймаг бүрт болон нийслэл Улаанбаатар хотод нийт 22 Аймаг нийслэлийн сонгуулийн хороо (АНСХ), сум болон дүүрэгт 339 Сум дүүргийн сонгуулийн хороо (СДСХ), мөн 1983 сонгуулийн хэсгийн хороо (СХХ) байгуулагджээ. Доод шатны сонгуулийн хороодын бүрэлдэхүүний дийлэнхийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна.<sup>7</sup> СЕХ-ноос боловсруулсан хөтөлбөрийн дагуу бүх шатны сонгуулийн хороодод сургалтууд цаг хугацаандаа тогтмол зохион байгуулагджээ.

Гаднаас нь харахад сонгуулийн байгууллага нь намын харьяалал огт харгалздаггүй, мерит зарчимд суурилсан байгууллага бөгөөд бүх шатны хороодод ажиллах гишүүдийг сургаж бэлтгэгдсэн, мэргэшсэн төрийн албан хаагчдаас сонгон шалгаруулжээ. Хорооны гишүүн бүрийг харьяа орон нутгийн иргэдийн хурлаас бэлтгэн гаргасан төрийн албан хаагчдын жагсаалтыг үндэслэн томилсон байна. Гэвч энэхүү сонгон шалгаруулах явцыг зохицуулах тусгай журам байхгүй бөгөөд хороод нь иргэдийн хурал дахь эрх мэдлийн хуваарилалтыг харгалзах хандлагатай байна. 2016 оны сонгуультай харьцуулахад энэ удаагийн сонгуулийн хороодын бүтэц бүрэлдэхүүнд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан нь ажиглагдав.<sup>8</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс энэ өөрчлөлтүүд нь 2016 оны сонгуулийн мөчлөгийн дараа орон нутгийн иргэдийн хурлуудад гарсан эрх мэдлийн шилжилттэй холбоотой гэж байв. Энэ байдал нь уг сонгуулийг зохион байгуулахад нөлөөлөөгүй мэт боловч энэ нь сонгуулийн хороодын томилгоонд намын харьяалал харгалзсан байж болохыг харуулж байна.

22 АНСХ-ны 21-ийг нь аймгийн ЗДТГ-ын дарга (8), ЗДТГ-ын хэлтсийн дарга (9), аймгийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга (4) нар даргалжээ.<sup>9</sup> Ийнхүү сонгуулийн хороодын удирдлагууд нь улс төрийн албан тушаалтнуудын шууд удирдлага дор ажиллаж байгаа нь бие даасан байх тухай ойлголттой нийцэхгүй байна.

СТХ болон СЕХ-ны дүрэм журамд сонгуулийн хороодын хуралдаан, хэлэлцэх асуудлуудыг олон нийтэд зарлан мэдээлж байх ёстой гэж заасан байдаг. Хуралдаанууд нь нээлттэй ил тод байж, хурлын тэмдэглэл зэргийг хөтөлж, аудио бичлэг хийгдэх ёстой. Хэдийгээр СЕХ нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлууд болон шийдвэрүүдээ цахим хэлбэрээр нийтэлж байсан ч доод шатны хороодод энэ журам тэр бүр хэрэгжсэнгүй. Эдгээр хороод дээр болсон хурлуудыг ихэнхдээ олон нийтэд мэдээлэлгүй, хэлэлцэх асуудлуудыг урьдчилан мэдэгдэлгүйгээр хийж, мөн хурлаас гарсан шийдвэрийн үр дүнг тэр бүр олж тодорхойлох боломжгүй байлаа. Зарим АНСХ болон СДСХ-д мэдээлэхдээ хуралдаанууд нь олон нийтэд дандаа нээлттэй байдаггүй гэж байсан бол, зарим нь хэлэлцэж буй асуудлууд нь хамааралтай тохиолдолд л намуудыг урьж оролцуулдаг гэж ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд мэдэгдсэн. Тиймээс хууль эрх зүйн орчноор

<sup>5</sup> Европын зөвлөлийн [Хуулиар ардчилал тогтоох хороо \(Венецийн Комисс\)-ны Сонгуультай холбоотой сайн туршлага](#) (Сайн туршлагын дүрэм)-ын II.3.1.f хэсэгт “сонгуулийн хороодын гишүүдийг томилж буй эрх бүхий байгууллагууд нь тэднийг дур мэдэн халах ёсгүй” гэж зөвлөдөг.

<sup>6</sup> СЕХ нь хуульд заасан бусад үүргээс гадна сонгуулийн төсвийг хянах, Аймаг нийслэлийн хороо (АНСХ)-дыг байгуулах, нэр дэвшигчдийг бүртгэх, саналын хуудасны загварыг баталж, хэвлүүлэх, сонгуулийн сурталчилгааны зардлыг хянах, АНСХ-дын шийдвэрийг эсэргүүцэн гаргасан өргөдөл гомдлыг хянах, сонгуулийн дүнг гаргах зэрэг үүрэгтэй.

<sup>7</sup> 188 АНСХ-нд ажиллаж буй гишүүдийн ерэн долоо нь эмэгтэйчүүд байна. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд СДСХ-доос өгсөн мэдээллээр үүнээс ч олон эмэгтэйчүүд ажиллаж байгааг харуулж байна.

<sup>8</sup> 2016 оны УИХ-ын сонгуулиас АНСХ-дын гишүүдийн далан зургаан хувь нь өөрчлөгджээ. Зөвхөн гурван АНСХ-ны дарга л солигдоогүй байв. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчдын очсон СДСХ-дод халаа сэлгээ харьцангуй бага хийгдсэн боловч бас л мэдэгдэхүйц байв.

<sup>9</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчдын очсон СДСХ-д дээр мөн л орон нутгийн засаг даргын тамгын газрын болон иргэдийн хурлын дээд албан тушаалын ажилтнуудаас томилсон байдал харагдаж байлаа.

тогтоож өгсөн сонгуулийн байгууллагын ил тод байдал ямар нэг хэмжээнд буурсан байна. Гэвч хэд хэдэн АНСХ ил тод байдлаа сайжруулахын тулд нийгмийн сүлжээг идэвхтэйгээр ашиглаж байсан нь сайшаалтай.

СЕХ сонгогчдод сонгуулийн талаар мэдлэг мэдээлэл өгөх нэлээд хэдэн арга хэмжээг хийж хэрэгжүүлсэн нь олон улсын хэм хэмжээтэй нийцсэн ажил байлаа.<sup>10</sup> Иргэдийн сонгох эрх, сонгуульд санал өгөх үйл явц зэргийг тайлбарласан гарын авлагыг орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад байрлаж буй мэдээллийн төвүүдэд хүргүүлж, сонгуулиас хэдэн долоо хоногийн өмнө олон нийтэд зориулсан мэдээллийг үндэсний радио, телевизээр нэвтрүүлсэн. АНСХ-д мөн үүнтэй ижил төстэй мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулсан байна. СДСХ болон СХХ-д санал өгөх цаг, санал авах байрны байршлын талаарх мэдэгдлийг сонгогчдын гэрт хүргүүлжээ. Энэ мэт хүчин чармайлтууд нь сонгогчдод энэ сонгуультай холбоотой мэдлэг мэдээллийг өгч, сонгуульд оролцож саналаа өгөхөд нь тус дөхөм болсон.

Энэ удаагийн сонгууль нь Монгол Улсын хувьд санал тоолох төхөөрөмж (СТТ) ашиглан явуулж буй зургаа дах сонгууль юм. Сайшаалтай нь СЕХ төхөөрөмжийн ажиллагааг шалгах шалгалтыг намууд болон иргэд олон нийтийн ажиглагчдыг байлцуулан хийсэн. Улс төрийн нам бүрээс томилогдсон ажиглагчид ч, мөн иргэний нийгмийн байгууллагын ажиглагчид ч өөрсдөө бие даан шалгах боломжтой байсан. Энэхүү шалгалтын үр дүн нь уг төхөөрөмжийн үнэн зөв, аюулгүй ажиллаж байгааг олон нийтэд батлан харуулсан явдал болсон бол, эсрэгээрээ улс төрийн намууд уг төхөөрөмжийн үнэн зөвд эргэлзсэн мэдэгдэл хийж байлаа. СЕХ-нд төхөөрөмжийн програмын эх кодыг хянаж үзэх хүсэлт ирээгүй гэж мэдээлсэн. Техник хангамж болон програм хангамжийн хараат бус баталгаажуулалтыг үзэх хүсэлт ч ирээгүй, хуулинд ч заагаагүй байна. Ерөнхийдөө санал тоолох төхөөрөмжийн үнэн зөвд итгэлтэй байлаа.

## Сонгогчийн бүртгэл

Шүүхээр эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон болон гэмт хэргийн ангиллаас үл хамааран хорих ял эдэлж буй бүх этгээдээс бусад 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай бүх иргэн санал өгөх эрхтэй. Ингэж бүхэлд нь хязгаарласан нь ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй байна.<sup>11</sup>

Үндэсний иргэний бүртгэл, мэдээллийн сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн энэ удаагийн сонгуульд нийт 1,978,298 сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн бөгөөд үүний дотор 7,209 сонгогч гадаад улсад саналаа өгөхөөр бүртгүүлжээ. Сонгогч сонгогчийн нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ 3-р сарын 1-нээс эхлэн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар (ОӨУБЕГ)-ын цахим хуудаст нэвтэрч шалгах боломжтой байв. ОӨУБЕГ нь шинэчлэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг АНСХ-д болон Улаанбаатар хотын есөн дүүргийн сонгуулийн хороодод 5-р сарын 31-ний дотор цахимаар болон цаасаар хүргүүлсэн бөгөөд эдгээр нь доод шатны сонгуулийн хорооддоо хүргүүлэв. СТХ-нд санал авах байр нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн ил тавьж, сонгогчдод чөлөөтэй

<sup>10</sup> ИУТЭОУП-д өгсөн [НҮБ-ын Хүний эрхийн хороо \(НҮБХЭХ\)-ны 25-р Ерөнхий](#) тайлбарын 11 дэх хэсэгт “гишүүн улсууд нь санал өгөх эрхтэй бүх хүн энэхүү эрхээ эдлэх боломжоор хангагдах үр дүнтэй арга хэрэгслийг авч хэрэгжүүлэх ёстой” [...] 25-р зүйлд заасан эрхийг эдлэх боломжийг хангахын тулд сонгогчдын боловсрол болон сонгогчдын бүртгэлд бүртгэх ажил чухал шаардлагатай” гэжээ.

<sup>11</sup> [ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагений Баримт бичгийн](#) 24 дэх хэсэгт “ардчилсан нийгэмд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа заалт нь холбогдох хуулийн аль нэг зорилттой уялдаж байхаас гадна тухайн хуулийнхаа зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэж заажээ. Мөн “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн [НҮБХЭХ-ны 25-р Ерөнхий](#) тайлбарын 14 дэх хэсэгт “хэрэв гэмт хэрэгт оногдуулж буй ял шийтгэл нь санал өгөх эрхийг нь түдгэлзүүлэх үндэс болсон бол ийнхүү түдгэлзүүлсэн хугацаа нь үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял шийтгэлтэй тохирч байх ёстой” гэжээ.



танилцах бололцоог олгоно гэж заасан бөгөөд сонгогч өөрийн мэдээллийг биечлэн шалгах долоо хоногийн хугацаатай байдаг. Гэвч энэхүү заалтыг тэр бүр ягштал биелүүлээгүй. Нилээд олон газар сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалагдах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэл учруулсан. Нөгөөтэйгүүр зарим СДСХ, СХХ-д сонгогчийн нэрийн жагсаалт дахь мэдээллийг шалгах ажлыг идэвхтэй явуулж байсан нь сайшаалтай. Ерөнхийдөө ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны уулзаж ярилцсан хүмүүс сонгогчийн бүртгэлийн явцын үнэн зөв, сонгогчдыг ялгаварлахгүйгээр хамруулсан гэдэг итгэж буйгаа илэрхийлсэн.

Сонгогч өөрийн байнга оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсгээс өөр аймаг руу шилжих бол 6-р сарын 11-ний өдрийн дотор энэ тухай хүсэлтээ өөрөө, эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан гаргах боломжтой. Ингэхдээ, сонгогч өөрийн оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсэгт шилжих тухай хүсэлтээ гаргаад, улмаар шилжин очсон сонгуулийн хэсэгт бүртгүүлнэ. Нийтдээ 1,927 сонгогч буюу 1 хувь хүрэхгүй сонгогч сонгуулийн хэсгээсээ шилжсэн байна. Санал өгөх газраа солих боломж иргэнд олгож буй нь сонгогчдын сонгох эрхэнд нөлөөлөх эерэг туршлага юм. Гэвч сонгогч шилжин явах хугацаа харьцангуй богино байдаг тул сонгогчдын нэрийн жагсаалтыг хугацаанд нь ил тавиагүй нь сонгогчдын санал өгөх нөхцөлийг хөнгөвчилж өгсөнгүй. Сонгогчийн шилжилтийг аймаг дотор хийхийг хориглосон заалт нь ерөнхийлөгчийн сонгуульд бодит ач холбогдолгүй бөгөөд сонгогчийн сонгуулийн эрхийг хязгаарлах эрсдэлтэй юм.<sup>12</sup>

### Нэр дэвшигчийн бүртгэл

СЕХ нь УИХ-д суудалтай гурван намаас дэвшүүлсэн гурван хүнийг сонгуульд нэр дэвшигчээр бүртгэсэн. Бусад нам нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд бие даан нэр дэвшихийг хуулиар зөвшөөрдөггүй. Эрх бүхий нэр дэвшигч нь 45 нас хүрсэн, Монгол Улсын харьяат эцэг эхээс төрж, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан байх ёстой. Нэр дэвшигч нь зээл, барьцаа, хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөр, эсвэл эрүүгийн гэмт хэргийн бүртгэлгүй байх шаардлагатай. Хэдийгээр ерөнхийлөгчид нэр дэвшихэд тодорхой шалгуурууд тогтоож болох ч, одоогийн тавигдаж буй шаардлагууд хэтэрхий хатуу байгаа бөгөөд сонгогдох эрхийн тухай ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй, сонгогчдын сонголтыг хязгаарлаж байна.<sup>13</sup>

Нэр дэвшүүлэх эцсийн хугацаанд буюу 5-р сарын 6-ны өдрөөс өмнө УИХ-д суудалтай гурван нам бүгд нэр дэвшигчээ шалгаруулах дотоод сунгааг хийсэн боловч энэ нь тэр бүр сайтар тодорхойлсон, ил тод шалгуурын дагуу явагдаагүй.<sup>14</sup> СЕХ нь АН болон МАН-ын нэр дэвшигчдийг бүртгэж, харин МАХН-аас нэр дэвшигчийг нэр дэвшихээс өмнөх хугацаанд Монгол Улсад байнга оршин суугаагүй гэх үндэслэлээр бүртгэхээс татгалзсан.<sup>15</sup> МАХН энэ

<sup>12</sup> Сонгогч шилжин явахтай холбоотой хязгаарлалтууд нь өөрийн оршин суугаа газрын харьяа сонгуулийн хэсгээс алслагдмал суугаа малчид, эмнэлэгт эмчлүүлж буй өвчтөн, сонгуульд ажиллаж буй цагдаагийн ажилтнуудын иргэний болон сонгуулийн эрхийг хасах эрсдэлтэй байна.

<sup>13</sup> “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-ын 25-р зүйлд өгсөн [НҮБХЭХ-ны 25-р Ерөнхий тайлбарын](#) 15 дахь хэсэгт “Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүмүүс нь боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл, эсвэл улс төрийн харьяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй” гэж заасан байдаг. ЕАБХАБ-ын [1990 оны Копенгагений Баримт бичгийн](#) 7.5 дахь хэсэгт “Гишүүн орнууд нь иргэдийн улс төрийн болон нийтийн албан тушаал хаших эрхийг ялгаварлан гадуурхалгүйгээр хүндэтгэнэ” гэж заажээ. Цаашлаад 24 дэх хэсэгт эрх, эрх чөлөөг хязгаарлах хязгаарлалтууд нь “тухайн хуулийн зорилготой хатуу нийцэж байх ёстой” гэжээ. Мөн [Сайн туршлагын дүрмийн](#) II.1.b хэсгийг үзнэ үү.

<sup>14</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Венецийн комиссын “[Улс төрийн намын зохицуулалтын тухай удирдамж](#)”-ийн 113 дахь хэсэгт “нэр дэвшигчийг ил тод шалгуурын дагуу шалгаруулна” гэж заасныг үзнэ үү.

<sup>15</sup> СЕХ нь МАХН-ын нэр дэвшигч болон түүний төлөөлөгчдийг хуралдаандаа оролцуулсан. Хуралдаанд ажиглагчид болон хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцоогүй.

шийдвэрийг давж заалдахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан ч, 6 дугаар сарын 9-ний өдөр шүүхээр хэлэлцээд, СЕХ-ны шийдвэрийг хэвээр үлдээсэн. МАХН эл шийдвэрийг давж заалдахаар Улсын дээд шүүхэд гомдол гаргасан боловч сонгуулийн өдөр гэхэд шийдэгдээгүй хэвээр байгаа нь иргэдийн хуулиар хамгаалуулах эрхийг зөрчиж буй явдал бөгөөд цаашид сонгуультай холбоотой өргөдөл гомдлыг хянан хэлэлцэх хугацааг богиносгох хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.<sup>16</sup> МАХН-ын анхны нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсаны дараа тус нам хуульд заасан хугацаанд багтаан өөр нэр дэвшигчийг нөхөн дэвшүүлсэн ба СЕХ уг нэр дэвшигчийг албан ёсоор бүртгэж авсан.

## Сонгуулийн сурталчилгааны орчин

Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаагаа 6-р сарын 6-ны өдөр эхэлсэн бөгөөд санал авах өдрөөс 24 цагийн өмнө дууссан. СТХ-иар сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон бүхий л харилцааг нарийвчлан зохицуулж өгсөн байдаг. Орон нутгийн засаг захиргааны болон сонгуулийн байгууллага нь гадаа сурталчилгааны зурагт самбар байрлуулах газруудыг хуваарилах, мөн нэр дэвшигчдийн сонгуулийн штабын ажилтнууд, сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслүүдийг бүртгэх зэргээр сонгуулийн сурталчилгааг зохицуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Сурталчилгааны зорилгоор бэлэн мөнгө, эд зүйл тараах болон амлах, үйлчилгээ үзүүлэх, хувьцаа өгөх, ажилд зуучлах, нийтийг хамарсан тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт зэргийг зохион байгуулах, ивээн тэтгэх хориотой.

Нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас Монгол Улсын эдийн засаг, хөгжлийн бодлогод нийцэж байгаа эсэхийг шалган, урьдчилан батлах ёстой байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, улс төрийн олон ургалч үзлийг шаардлагагүйгээр хязгаарлаж буй явдал юм. 5-р сарын эхээр ерөнхийлөгчийн сонгуульд оролцож буй гурван нам мөрийн хөтөлбөрөө ҮАГ-т өгчээ. Намуудын мөрийн хөтөлбөрт нийт 208 зорилт тусгагдсанаас 41 зорилтыг нь ҮАГ зохих засвар өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай гэж үзжээ. Намуудын зохих засвар өөрчлөлтүүд оруулсан мөрийн хөтөлбөрүүдийг 5-р сарын 10-нд баталжээ.

Сонгуулийн сурталчилгаа өрсөлдөөнтэй явагдаж, иргэд сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхээ эдэлж чадлаа. Нэр дэвшигчид нийслэл Улаанбаатар болон 21 аймгаар богино хугацаанд явж, сонгуулийн сурталчилгааны хурал цуглаануудад оролцон, иргэд сонгогчидтой уулзлаа. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь сум, багийн хэмжээнд зохион байгуулагдсан улс төрийн үйл ажиллагааг оролцуулаад нийт 60 хурал цуглаан ажиглалаа. МАН болон АН-аас зохион байгуулсан сонгуулийн сурталчилгааны хурал уулзалтууд дээр заал танхимуудыг тухайн аймаг дахь намуудын зуу зуун дэмжигчид дүүргэж, үйл явдлыг том дэлгэцээр гадаа байгаа хүмүүст зориулж шууд дамжуулж байв<sup>17</sup>. Ерөнхийдөө МАН болон АН-ын сурталчилгааны хурал уулзалтууд зохион байгуулалт өндөртэй болж байлаа. Хэдийгээр МАХН-ын хурал цуглаануудын цар хүрээ харьцангуй жижиг байсан ч, нэр дэвшигч сонгогчидтой нүүр тулж уулзах илүү боломжтой, харьцангуй чөлөөтэй болж байв.

Нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны хурал уулзалтууд дээр өөрийн улс төрийн зорилго, зорилтуудаа танилцуулж байв. Сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө сөрөг агуулгатай байсан бөгөөд АН болон МАХН-ын нэр дэвшигчдийн сурталчилгаа тэр талаараа илүү ялгарч байв.

<sup>16</sup> [ЕАБХАБ-ын 1990 оны Копенгагены баримт бичгийн](#) 5.10 дахь хэсэгт “үндсэн суурь эрхийг хүндэтгэж, хууль эрх зүйн шударга байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны гаргасан шийдвэрийг эсэргүүцэн барагдуулах үр дүнтэй арга хэрэгслийг авах эрхтэй байна” гэж заажээ.

<sup>17</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны тооцоолсноор хамгийн том хэмжээний сонгуулийн сурталчилгааны цуглаанд 4,500 орчим хүн оролцсон Улаанбаатар хотод болсон АН-ын цуглаан байв. Харин орон нутагт зарим цуглаанд 40-50 хүн, аймгийн төвүүдэд 400-аас 800 орчим хүн оролцож байв.



МАН-ын нэр дэвшигч нь эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж буй өөрийн намын амжилтуудыг онцлох байдлаар нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах тухай мөрийн хөтөлбөрөөрөө сурталчилгаа явуулсан. Харин АН болон МАХН-ын нэр дэвшигчид авилгатай холбоотой асуудлууд, мөн ядуурал, гаднын ашиг сонирхолд үйлчлэх, уул уурхайн орлогын шударга бус хуваарилалт зэрэг асуудлууд дээр төвлөрч байлаа. Хэдийгээр МАН болон МАХН өөрсдийгөө зүүн-төвийн, харин АН баруун-төвийн үзэл баримтлалтай гэх боловч нэр дэвшигчдийн хувьд үзэл суртлын ялгаа бараг мэдрэгдсэнгүй.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажилласан есөн аймагт зохион байгуулагдсан МАН-ын бараг бүх цуглаанд тухайн намын харьяалалтай засаг дарга нар оролцож байлаа.<sup>18</sup> Төрийн захиргааны өндөр албан тушаалтнууд АН-ын зарим цуглаанд мөн оролцжээ. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-нд төрийн байгууллагын өмч хөрөнгийг буруугаар ашиглан зөрчил гаргасан тохиолдлууд гарч байгаа талаар мэдээллүүд ирж байсан бөгөөд зарим үед ийм үйлдлүүд шууд ажиглагдаж байв<sup>19</sup>. Түүнчлэн төрийн ажилтнууд сонгуулийн сурталчилгааны цуглаануудад оролцсон хууль бус үйлдлүүд ажиглагдаж байв.<sup>20</sup> Сонгуулийн санал хураалт болохоос хэдхэн хоногийн өмнө засгийн газраас эд материалын болон санхүүгийн чанартай амлалт өгсөн тохиолдлууд бүртгэгдсэн.<sup>21</sup> Энэ нь төрийн захиргааны байгууллагын албан ёсны үйл ажиллагаа болон улс төрийн сурталчилгааны хоорондох зааг ялгаа холилдоход хүргэж буй явдал юм.

Улс төрийн нам болгон аймгийн төвүүд дээр гэр барьж, намын дэмжигчид сурталчилгааны материал тарааж байв. Орон нутгийн захиргааны байгууллагууд сонгуулийн сурталчилгааны зурагт хуудас, зарлалын самбарууд байрлуулах цэгүүдийг тогтоож өгсөн бөгөөд гадаах сурталчилгаа 6-р сарын 6-наас хойш төвийн хэсгүүдээр ихэссэн. МАН, АН хоёр Улаанбаатар хот болон аймгуудад ойролцоо тооны сонгуулийн сурталчилгааны зурагт хуудас, зарлалын самбарууд байрлуулсан байсан бол, МАХН ялангуяа санхүүгийн шалтгаанаар харьцангуй бага тооны сурталчилгааны материал байршуулж байв.<sup>22</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-той МАН болон АН-аас уулзаж ярилцсан хүмүүс зарлалын самбарууд байршуулах цэгүүдийг ялгавартай хуваарилж байгаа талаар дурдаж байв.<sup>23</sup> Мөн нэр дэвшигчдийн сурталчилгааны зурагт хуудсыг нүүргүй болгож, бүр авч хаясан тохиолдол олон гарчээ.<sup>24</sup>

Сонгуулийн сурталчилгаа эхлээгүй байхад хүртэл хэвлэл мэдээллээр намуудын төлбөртэй болон редакцын агуулга бүхий нэвтрүүлгүүд аль аль нь гарч байв. Түүнчлэн авилга, гаднын ашиг сонирхолтой хуйвалдсан гэх нотлогдоогүй хардлагууд, мөн гаднынхныг гадуурхах, арьс өнгөөр ялгаварласан хэл яриа, хэт туйлшрал болон хүчирхийлэлд өдөөн турхирсан агуулгууд

<sup>18</sup> Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар, Өмнөговь, Увс зэрэг аймаг.

<sup>19</sup> Тухайлбал, Говь-Алтай аймгийн засаг дарга албаны унаатайгаа тав хоног сумдаар явсан байна. Мөн Баянхонгор аймгийн засаг даргын Facebook-ын хуудас МАН-ын сонгуулийн материалуудыг сурталчилж байв.

<sup>20</sup> Тухайлбал, 6 сарын 14-нд Булган, Хөвсгөл аймгуудад, 6 сарын 17-нд Увс аймагт тус тус болсон МАН-ын цуглаан.

<sup>21</sup> Тухайлбал, 6 сарын 14-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хотын захад оршин суух гэр хорооллын иргэдэд орон сууц барьж өгөх талаар хэлэлцсэн, мөн тэр өдөр 2018 оны 1-р сарын 1-нээс тэтгэвэр нэмэх талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хийсэн мэдэгдэл.

<sup>22</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ 10 аймгийн төвийг хамарсан гадаах сурталчилгаанд тоон үнэлгээ хийсэн байна. Уг судалгаагаар нийт сурталчилгааны самбар болон зурагт хуудаснуудын 48% МАН, 33% АН, харин 18% МАХН-ынх байв.

<sup>23</sup> Тухайлбал, Ховд болон Өмнөговь аймгуудад.

<sup>24</sup> Хэнтий аймгийн Чингис суманд МАН болон МАХН-ын нэр дэвшигчдийн сурталчилгааны зурагт хуудсыг нүүргүй болгосон. Ховд аймаг дахь Аймгийн сонгуулийн хороо квот хэтэрсэн гэдэг үндэслэлээр АН-ын зурагт хуудаснуудыг буулгах шийдвэр гаргасан. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид Улаанбаатар хот, Өмнөговь аймагт МАН-ын олон зурагт хуудас алга болсныг харжээ.

цацагдаж байлаа.<sup>25</sup> Ийм тохиолдлууд сонгуулийн санал хураалт явагдахаас өмнөх хэд хоногт улам олширсон.<sup>26</sup> Мөн нэгэн нэр дэвшигчийн төрийн албыг хууль бусаар зарсан гэх дүрс болон аудио бичлэгүүд олон нийтэд цацагдсан нь сонгуулийн үйл явцад нөлөөлөв.<sup>27</sup>

Сонгуулийн сурталчилгааны үеэр нийгмийн сүлжээ чухал үүрэг гүйцэтгэлээ. Бүх нэр дэвшигч өөрийн нүүр ном буюу Facebook хуудас, МАН болон АН-ын нэр дэвшигчид жиргээ буюу Twitter болон хувийн цахим хуудсаа ашиглаж сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагаагаа сурталчилсан байна. Facebook хуудас дээр АН-ын нэр дэвшигч нөгөө хоёр нэр дэвшигч нийлээд хүрэхээргүй хэмжээний их хандалттай байв. МАН болон АН-аас сонгогчдод нийгмийн сүлжээнд идэвхтэй оролцох боломж олгох үүднээс гар утасны аппликейшнийг гаргажээ. ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны ажиглагчид нийгмийн сүлжээнд нэгдсэн зохион байгуулалттай агуулга, тэр дундаа нэр дэвшигчдийг харлуулах зорилготой санал, сэтгэгдэлүүд агуулсан үйл ажиллагаа явагдсаныг онцолсон байна.<sup>28</sup> Нийгмийн сүлжээг сонгуулийн луйврын талаар сэжиглэж буй мэдээллээ тараах, мөн сонгуулийн үйл явц шударга явагдаж буйд эргэлзээ төрүүлэхэд өргөн ашиглаж байлаа. Сонгуулийн сурталчилгааны хугацаа дууссан хойно ч нэр дэвшигчид сөрөг сурталчилгааг олон нийтийн хэрэгслээр явуулсаар байв.

Нийгэм, улс төр дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудал нэр дэвшигчдийн сонгуулийн сурталчилгаанд ч, мөн хэвлэл мэдээллээр ч бараг хөндөгдөөгүй. Хэдий тийм боловч жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн улс төрийн түвшин дэх оролцоог нэмэгдүүлэх санал санаачилга МАН болон АН-ын мөрийн хөтөлбөрт тус тус тусгагджээ. Ажиглалт хийсэн сонгуулийн сурталчилгааны цуглаануудад оролцсон хүмүүсийн 50 орчим хувь нь, мөн бага тушаалын сонгуулийн менежерүүд дунд олон эмэгтэйчүүд байв.

Сонгуулийн сурталчилгаа ерөнхийдөө монгол хэл дээр явагдав. Сонгуулийн сурталчилгааны материалыг казах хэл дээр орчуулж, мөн энэ хэл дээр сонгогчдод хандаж үг хэлсэн хэд хэдэн тохиолдол зөвхөн казах үндэстэн голдуу оршин суудаг Баян-Өлгий аймагт ажиглагдсан. Сонгуулийн сурталчилгааны үеэр үндэсний цөөнхүүдийн талаарх асуудал ерөнхийдөө хөндөгдөөгүй өнгөрсөн байна.

## Сонгуулийн сурталчилгааны зардал

Сонгуулийн сурталчилгааг хандиваар болон нэр дэвшигчдийн хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. СТХ-иар хандивын хэмжээг иргэний хувьд 3 хүртэл сая төгрөг, хуулийн этгээдийн хувьд 15 хүртэл сая төгрөг байхаар хязгаарлажээ.<sup>29</sup> Бэлэн мөнгөөр өгч буй бүх хандив нь тодорхой банкны дансаар дамжуулан хийгдэх ёстой. Мөнгөн бус хандивыг зардлын хязгаараар тогтооно. Аймгуудад ихэнх сонгуулийн сурталчилгааны зардлыг намын төв байраас

<sup>25</sup> Тухайлбал, “Улаан тарианы хүүхдүүд” гэдэг баримтат кино нэр нь дурдагдаагүй авилгын хэрэгт холбоотой албан тушаалтнуудыг хууль бусаар алахыг уриалсан агуулгатай байв. Уг баримтат кино нь нэр дэвшигчдийн нэгэнтэй нь холбоотой гэдэг нь олонд мэдэгдсэн нэгэн компанийн хийсэн кино бөгөөд 5-р сарын 29-ний өдөр нийт 5 телевизийн оргил цагийн нэвтрүүлгээр цацагдсан.

<sup>26</sup> Тухайлбал, 6-р сарын 18-нд МАН-ын штабаас гаргасан “Эх орончийн багт наадам” гэсэн баримтат кинонд АН-ын нэр дэвшигчийг хятадын бизнесменүүдтэй холбоотой, мөн хятад ажилчид оруулж ирж байгаа зэргээр буруутгасан агуулгатай байв. Уг баримтат кино *Eagle TV /Ийгл ТВ/* болон *MNB /МНБ/* телевизийн нэвтрүүлгээр намын сурталчилгаа хэлбэрээр, мөн нийгмийн сүлжээгээр тус тус цацагдсан. Мөн, 6-р сарын 21-нд АН-ын штабаас олон нийтэд ил болгосон нууц бичлэг дээр үндэслэн гаргасан “60 тэрбумын аархал” гэсэн 3 хэсэгтэй баримтат кинонд МАН-ын нэр дэвшигчийг СЕХ-той хуйвалдаж 2016 оны УИХ-ын сонгуулийг луйвардсан, мөн хятадын эдийн засгийн ашиг сонирхолд үйлчилдэг гэх агуулгатай байв.

<sup>27</sup> АН-аас МАН-ын нэр дэвшигчийг төрийн албыг наймаалж, ашиг олох гэж байна гэж буруутгасан. Мөн АН-ын нэр дэвшигчийг авилгын хэрэгт холбоотой гэж буруутгав.

<sup>28</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ нь улс төрийн намууд, нэр дэвшигчид, үзэл бодлын манлайлагчид, хэвлэл мэдээллийн байгууллагуудын Facebook дээрх 20 хуудсыг түүвэрлэн ажиглав.

<sup>29</sup> 1,135 евро ба 5,680 евротой тус тус тэнцэнэ. 1 евро ойролцоогоор 2,640 төгрөг.

хуваарилсан хөрөнгөнөөс гаргасан, мөн намууд орон нутгаасаа хөрөнгө босгосон. АН болон МАХН-аас нэр дэвшигчид хандив цуглуулахдаа нийгмийн сүлжээ ашигласан бол, МАН хандив цуглуулах ажлаа сонин хэвлэлээр сурталчилжээ. Үүний сацуу МАХН-ын нэр дэвшигч сонгуулийн кампанит үйл ажиллагааны үеэрээ бэлэн мөнгөний хандив гуйсан байна.<sup>30</sup>

Авилгатай тэмцэх газар (АТГ)-аас 6-р сарын 14-нд гурван нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг олон нийтэд зарласан. Нэр дэвшигчид хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ өөрийн болон гэр бүлийн орлого, эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгө, унаа тэрэг, аж ахуйн нэгжийн хувьцаа, малын тоо толгой зэрэг харьцангуй дэлгэрэнгүй мэдээллийг тусгажээ.<sup>31</sup> Нэр дэвшигчид хөрөнгө, орлогын мэдүүлгээ өөрийн тооцоолж үнэлснээр гаргасан байна. Гэсэн хэдий ч, эдгээр мэдүүлэгт эзэмшиж буй хөрөнгийн үнэлэмж, мөн ямар үндсэн хөрөнгө нэр дэвшигчдийн ойрын гэр бүлийн гишүүдийн эзэмшилд байдгийг тодорхой зааж тусгаагүй байна. Дээрх байдал нь сонгогчдод нэр дэвшигчдийн санхүүгийн талаар үнэн зөв төсөөлөлтэй болох боломж олгохгүй байгаа юм. Нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн үнэн зөв эсэхэд олон нийт АТГ-т хандан гомдол гаргах боломжтой. АТГ нь ийм гомдол хүлээж авснаас хойш 19 хоногийн дотор мөрдөн шалгах үүрэгтэй. Шалгалттай холбоотой шийдвэр нь зөвхөн сонгууль дууссаны дараа гарах учраас сонгогчид санал өгөхөөсөө өмнө нэр дэвшигчдийн талаар баталгаатай мэдээлэл авах боломжгүй байна.

Нэр дэвшигчдэд өрсөлдөх боломж, нөхцлийг ижил тэгш байлгахын тулд ҮАГ нь сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаарыг 10.7 тэрбум төгрөг байхаар тогтоожээ.<sup>32</sup> Үүнд улс төрийн сурталчилгаанд 2.6 тэрбум төгрөг, шатахуунд 1.7 тэрбум төгрөг, сонгуулийн сурталчилгааны ажилчдын *албан томилолтын* зардалд 1.9 тэрбум төгрөг тус тус багтжээ.<sup>33</sup> Сонгуулийн сурталчилгаанд ажилласан хүмүүсийн цалин гэж тусад нь хуваарилсан зардал байхгүй ч, ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны тооцоолж буйгаар энэ нь зардлын төрлүүдээс хамгийн өндөр гэж үзэж байна.<sup>34</sup> ҮАГ нь зардлын төрөл тус бүрээр хязгаар тогтоох ил тод, хүчтэй тогтолцоо байхгүй, мөн сонгуулийн сурталчилгааны зардлын хязгаар тогтоох шийдвэр гаргахаасаа өмнө сонгуулийн оролцогч талуудтай зөвлөлдөөгүй. Нэр дэвшигчдийн үүрэгт ажлаа хийж байхдаа гаргасан ололт амжилтыг сонгуулийн сурталчилгаанд тооцдоггүй тул энэ нь сонгуулийн сурталчилгааны хязгаарлалтад хамаарахгүй.

ҮАГ нь анх удаа намуудын зардлын тайлангийн үнэн бодит эсэхийг тогтоохын тулд аймгуудад буй намуудын сонгуулийн штабуудад урьдчилан мэдэгдэлгүйгээр шалгалт хийв. Гэвч ҮАГ нь орон нутаг дахь салбарууд төдийгүй намуудын тайлангийн загварыг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө боловсруулж бэлэн болгоогүй, мөн сонгуулиас өмнө намуудын орлого, зардлын

<sup>30</sup> Хандив өгсөн хүмүүсийн овог нэр, регистрийн дугаарыг авч, дараа нь цугларсан бэлэн мөнгийг банкин дахь сонгуулийн сурталчилгааны дансанд хийжээ. Гэвч сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийг ингэж бэлэн мөнгөний хандивын хайрцагар цуглуулах арга нь хариуцлагатай байдал хийгээд СТХ-ийн холбогдох заалтуудтай нийцэж байгаа эсэхэд асуудал үүсгэж байна.

<sup>31</sup> Авлигатай тэмцэх газраас мэдээлснээр АН-аас нэр дэвшигчийн хувийн орлого хамгийн өндөр (130 сая төгрөг), дараа нь МАН-аас нэр дэвшигч (91 сая төгрөг), МАХН-ийн нэр дэвшигч (23 сая төгрөг)-ний орлоготойгоор жагсжээ, гэхдээ хэрэв гэр бүлийн орлогыг оруулбал МАН-аас нэр дэвшигч 209 сая төгрөгний орлоготойгоор эхэнд жагсаж, дараа нь АН-аас нэр дэвшигч 161 сая төгрөг, МАХН-аас нэр дэвшигч 128 сая төгрөгтэй тус тус жагсжээ. АН-аас нэр дэвшигч мөн хэд хэдэн томоохон компанид хувьцаа эзэмшдэг.

<sup>32</sup> Нэр дэвшүүлж буй нам бүр улс орон даяар явуулах сурталчилгааны ажилдаа 6.8 тэрбум төгрөгийг зарцуулахаар заасан бол, нэр дэвшигчийн зардлыг 3.9 тэрбум төгрөг байхаар хязгаарлан өгчээ.

<sup>33</sup> *Албан томилолтын* зардлыг нэр дэвшигч тус бүрт 13,939 сонгуулийн сурталчилгааны ажилтан байхаар гаргаж, нэг ажилтанд дунджаар 136 мянган төгрөг ноогдох ба энэ нь сонгуулийн сурталчилгааны ажилтны унаа, хоолны зардалд зориулагджээ.

<sup>34</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-тай уулзаж ярилцсан хүмүүсийн тооцоолж буйгаар сонгуулийн сурталчилгааны ажилтнуудын цалин сонгуулийн сурталчилгааны бүхий л хугацаанд 100,000 төгрөгөөс 300,000 төгрөг байна.

тайланг ил болгох тухай ямар нэг заалт байсангүй.<sup>35</sup> Намуудаас аль нь ч сурталчилгааны зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг сайн дураар тайлагнасангүй.

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь санхүүгийн тайлангаа сонгууль дууссанаас хойш 30 хоногийн дотор ҮАГ-т хүргүүлэх үүрэгтэй. Тайлан хүргүүлэхээс өмнө нэр дэвшигчид ҮАГ-аас магадлан итгэмжлэгдсэн 54 аудитын байгууллагын нэгээс сонгож тайландаа аудит хийлгэнэ. ҮАГ нь аудит хийгдсэн тайланд зөвхөн чанарын хяналт хийх үүрэгтэй байна. Түүнээс гадна сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлэх, мөн хуурамч санхүүгийн тайлан гаргах зэрэг сонгуулийн хуулийг ноцтой зөрчсөн үйлдлүүд огт шийтгэлгүй байгаа явдал нь үр нөлөөтэй, адил тэгш шийтгэл өгөх зарчмыг зөрчиж, нэр дэвшигчдийн тэгш өрсөлдөх эрхийг хумиж буй юм. Бусад зөрчлүүдэд оногдуулах торгууль мөн бага байна. Хандив өгөхийг хориглосон этгээд болох олон улсын байгууллага, үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага зэргээс хандив авсан бол тухайн нэр дэвшигчийг нэр дэвшигчээс хасах хүртэл заалт бий. Гэвч нэгэнт сонгууль болоод өнгөрсөн хойно энэ заалтыг хэрэгжүүлэх боломжгүй.

### Хэвлэл мэдээлэл

Монгол Улсад 450 орчим хэвлэл мэдээллийн хэрэгсэл хязгаарлагдмал зар сурталчилгааны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр байгууллагууд ашигтай ажиллах нь бараг ховор, үнэндээ өмчлөгч эздийнхээ бусад бизнесээс ивээн тэтгүүлж явдаг. Ийм орчин нь эзэмшигчдийн зүгээс аль нэг талыг баримталсан нэвтрүүлэг явуулах зэргээр редакцийн бодлогод нөлөө үзүүлэх нөхцөлийг бий болгодог. Мөн засгийн газрын захиалгат, төлбөртэй зар сурталчилгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн орлогын мэдэгдэхүйц хувийг эзэлж байгаа нь өөрсдөдөө хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж байж болох юм. Тиймээс олон ургальч редакцийн бодлого дутагдаж байна. Мэдээлэл авах гол эх үүсвэр нь телевиз байгаа бол, хот суурин газарт интернет, ялангуяа нийгмийн сүлжээг өргөн дэлгэр ашиглаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг баталгаажуулсан боловч холбогдох хуулиар сайтар хамгаалж өгөөгүй. Хүний нэр төрд халдан гутаах хэргийг зөвхөн сонгуулийн дараа эрүүгийн гэмт хэрэгт тооцохоо больж байгаа. Түүнчлэн нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгасан Зөрчлийн тухай хуульд хүний нэр төр гутаах, гүтгэх, худал мэдээлэл тараах зэрэгт оногдуулсан торгуулийн хэмжээ нь өндөр байгаа бөгөөд нийгмийн сүлжээнд тавигдаж буй агуулгад мөн хамаарна.<sup>36</sup> Хэвлэл мэдээллийн байгууллагын өмчлөл, бүтцийг ил болгохыг шаардсан хуулийн зохицуулалт байхгүй.

Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжид мэдээллийн хэрэгслээр дамжуулах сонгуулийн сурталчилгааны чухал хэсэгтэй холбогдох заалтууд тодорхой бус байна.<sup>37</sup> Ямартай ч СТХ-иар хэвлэл мэдээлэл нь сонгуулийн

<sup>35</sup> [Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенцийн](#) 7 (3) зүйл зөвлөж буйгаар “Сонгогддог төрийн албан тушаалтны нэрийг дэвшүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болон холбогдох тохиолдолд улс төрийн намын санхүүжилтийн ил тод байдлыг дээшлүүлэх зорилгоор оролцогч улс бүр [...] хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээг авах асуудлыг мөн авч үзнэ”. 194 дэх хэсэг [ЕАБХАБ/АИХЭГ-ын болон Венецийн комиссын Улс төрийн намуудын зохицуулалтын удирдамж](#) зааж буйгаар “сонгогчид талуудыг хариуцлагтай байлгахын тулд улс төрийн намуудад олгож буй санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэл авсан байх эрхтэй”.

<sup>36</sup> ЕАБХАБ-ын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгчид [2016 оны 11-р сарын 23-нд](#) мэдээлэхдээ “хэрэв хүчирхийлэлтэй шууд холбогдоогүй бол хэнийг ч нийгмийн сүлжээгээр явуулсан үйл ажиллагааных нь [...] төлөө шийтгэгдэх ёсгүй” гэжээ.

<sup>37</sup> Тухайлбал, СТХ-ийн 70.1.6. болон 70.7-д олон нийтийн санал асуулга хэвлэн нийтлэхийг хориглох тухай хоорондоо зөрчилдсөн заалтууд байна. 82.5 болон 82.6 дахь заалтууд дээр улс төрийн төлбөртэй сурталчилгааг зөвхөн дөрөв ба түүнээс дээш нэр дэвшигчтэй тохиолдолд хязгаарлах тухай тодорхой заажээ.

үйл явцыг бодитойгоор мэдээлж, төлбөргүй нэвтрүүлгийн цагийн хуваарилалт, нэр дэвшигчдийн төлбөртэй нэвтрүүлгийн цагийн ашиглалт зэргийг зохицуулсан байдаг. СТХ-иар нэг нэр дэвшигчид оногдох мэдээний нэвтрүүлгийн цагийг өдөрт таван минут байхаар хязгаарлаж өгчээ. Хэдийгээр хуулиар мэдээний нэвтрүүлгийн цагаар сурталчилгаа явуулахыг хориглодог ч, Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ)-ноос үүнийг тайлбарлахдаа намуудын урьдчилан бэлтгэж, төлбөртэй нэвтрүүлж буй мэдээ маягтай клипийг мэдээний цагаар нэвтрүүлэх нь улс төрийн сурталчилгаанд тооцогдохгүй гэв. Тиймээс үндэсний хэмжээнд болон Улаанбаатар хотод төвтэй телевизүүдийн ихэнх нь мэдээний нэвтрүүлгийн цагаа ХХЗХ-нд ирүүлсэн үнийн саналын дагуу зарахаар санал болгожээ.<sup>38</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-ны хэвлэл мэдээллийн мониторингоос үзвэл төлбөртэй, хуурамч мэдээний сегментүүд таван минутын хязгаараас хэтэрч, редакцийн агуулгаас ялгагдахгүй байсан нь сонгогчдод улс төрийн ухуулга, эсвэл шударга мэдээллийн аль нь болохыг ялгахад хэцүү байв.

Монголын үндэсний олон нийтийн радио телевиз (МҮОНРТ) нь хуульд заасны дагуу нэр дэвшигч тус бүрт үнэ төлбөргүй болон мэдээний нэвтрүүлгийн цагийг олгосон.<sup>39</sup> Аливаа олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг, шударга байх зэрэг зарчимтай харшилж, нэр дэвшигчдийн талаарх мэдээний нэвтрүүлгүүд нь гол төлөв намуудаас ирүүлсэн сонгуулийн сурталчилгааны үйл явдлын мэдээнээс бүрдэж байсан нь сонгуулийн өдөр мэдээлэлд үндэслэсэн сонголт хийхэд тус болсонгүй.

Хувийн мэдээллийн хэрэгслүүдийн агуулга нь улс төрийн намын баримжаагаар тодорхойлогдож байв.<sup>40</sup> *Ийгл ньюс* нь МАН болон тус намаас нэр дэвшигчийг илэрхий дэмжиж байсан бол, АН-ын нэр дэвшигчид хамааралтай нэвтрүүлэг нь ихэвчлэн сөрөг өнгө аястай байлаа.<sup>41</sup> Үүнтэй эсрэг дүр зураг *С1* телевиз дээр ажиглагдаж байсан ба нэр дэвшигчдийн талаарх улс төртэй холбогдолтой мэдээний нэвтрүүлгийнхээ 29 хувийг АН, түүний нэр дэвшигчид зориулж, ерөнхийдөө эерэг өнгө аястай нэвтрүүлж байсан, харин МАН, түүний нэр дэвшигчтэй холбоотой нэвтрүүлэг нь сөрөг өнгө аястай байлаа. TV9 телевизийн мэдээний нэвтрүүлгүүд нь МАХН, түүний нэр дэвшигчийг дэмжсэн, харин МАН-аас нэр дэвшигчийг эерэгээр харуулсан тохиолдол байсан бол, намынх нь тухайд ихэвчлэн төвийг сахисан, бас сөрөг байдлаар харуулж байлаа.

Олон нийтийн телевиз 6-р сарын 24-ний өдөр мэтгэлцээнийг зохион байгуулж, гурван нэр дэвшигчийг шууд харьцуулах боломжийг сонгогчдод олгов. Мэтгэлцээн эмх журамтай явагдсан бөгөөд нэр дэвшигчид өөрсдийн амжилт ололтыг тэмдэглэн хэлж, авилгатай холбоотой мэдэгдлүүдийг няцааж, мөрийн хөтөлбөрөөсөө дурдаж байлаа. Мэтгэлцээн дээр нэр

<sup>38</sup> ХХЗХ-нд үнийн саналаа ирүүлсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хийсэн ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-ны хэвлэл мэдээллийн шинжилгээгээр үндэсний хэмжээнд болон Улаанбаатар хотод төвтэй 46 телевизээс 38 нь мэдээний нэвтрүүлгийн цагаа зарахаар санал болгожээ. Энэ үнийн саналыг ХХЗХ, СЕХ, хэвлэл мэдээллийн хэрэгслийн аль нь ч албан ёсоор нийтэлсэнгүй. ХХЗХ нь орон нутгийн телевизүүдийн үнийн саналын хувийг ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ-нд ирүүлээгүй, харин зарим үнийн саналыг СЕХ болон холбогдох АНСХ-доос танилцуулсан.

<sup>39</sup> 5-р сарын 26-нд СЕХ, ХХЗХ-ноос МҮОНТ-тэй хамтран нэр дэвшигч тус бүрт өдөр бүр 15 минутыг оргил цагийн үеэр, мөн 2 минутыг мэдээний хөтөлбөрийн үеэр үнэ төлбөргүй нэвтрүүлэхээр хуваарилсан. 6-р сарын 5-нд МҮОНТ нь мэдээний нэвтрүүлгийн цагийг таван минут болгож сунгав.

<sup>40</sup> ЕАБХАБ/АИХЭГ-ны САХХ нь 5-р сарын 29-нд хэвлэл мэдээллийн мониторинг эхлүүлсэн. Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь олон нийтийн радио телевиз (*МҮОНРТ*), арилжааны телевизийн дөрвөн суваг (*Ийгл ньюс*, *Монгол HD*, *TB5*, *TB9*) болон хувийн хэвшлийн таван сонин (*Өдрийн сонин*, *Өнөөдөр*, *Зууны мэдээ*, *Үнэн*, *Засгийн газрын мэдээ*) болно. Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлэхэд арилжааны *С1* телевизийг мониторингод нэмэв.

<sup>41</sup> Сонгуулийн сурталчилгааны үеэр *Ийгл ньюс* нь улс төртэй холбоотой нэвтрүүлгийнхээ 32 хувийг МАН болон тус намаас нэр дэвшигчид зориулсан. Үүний эсрэгээр АН, түүний нэр дэвшигчид ийм нэвтрүүлгийн 20 хувь ноогдож байв. МАН-ын нэр дэвшигчийг гол төлөв эерэгээр харуулж байсан бол, бусад нэр дэвшигчдийн тухай нэвтрүүлэг нь ихэвчлэн төвийг сахисан, эсвэл сөрөг өнгө аястай байлаа.



дэвшигчдийн дунд шууд харилцаа үүсээгүй бөгөөд мэтгэлцээн болсон студид үзэгч сонсогчид байгаагүй. МҮОНРТ-аас МАН-ын нэр дэвшигчид хандан сонгосон асуултууд түүнийг болон гэр бүлийг нь магтан сайшаасан агуулгатай байсан бол, МАХН-ын нэр дэвшигчид сонгосон асуултууд нь сонгуулийн сурталчилгааны үеэр түүний эсрэг гарч байсан гол асуудлуудыг хөндсөн.<sup>42</sup> Мэтгэлцээн зохион байгуулах санаачлага хувийн хэвшлийн телевизүүдээс гарч байсан боловч нэр дэвшигчид мэтгэлцээн болох газар, ямар хэлбэрээр мэтгэлцэх тал дээр тохирч чадаагүй тул бүтээгүй.

Төлбөртэй сонгуулийн сурталчилгааг ихэнхдээ оргил цагийн нэвтрүүлгийн үеэр нэг блок болгон худалдан авч байсан бөгөөд заримдаа нэг өдөрт нэг нэр дэвшигчид оногдох ёстой 15 минутын хязгаараас давж байлаа. Ийм нэвтрүүлгүүд нь сурталчилгааны хэсгүүд (21 хувь), сонгуулийн сурталчилгаанаас ирүүлсэн мэдээллийн хэсгүүд (56 хувь), өрсөлдөгчдөө шүүмжилсэн хэсгүүд (23 хувь)-ээс бүрдэж байв.<sup>43</sup>

Хэвлэл мэдээллийн салбарыг зохицуулж буй байгууллагууд болох ХХЗХ болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар (ШӨХТГ) нь мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй улс төрийн ялгаварлалтай нэвтрүүлгийн талаар хангалттай арга хэмжээг аваагүй. ШӨХТГ нь уламжлалт болон цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийт 20 сануулгыг өгсөн бөгөөд эдгээр нь ихэнхдээ сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө явуулсан сөрөг сурталчилгаа болон цахимаар тавигдсан олон нийтийн санал асуулгатай холбоотой байв. Гэвч сонгуулийн сурталчилгаатай холбогдох заалтуудыг зөрчсөн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг олон нийтэд ил зарлаагүй учраас энэ нь сонгогчдод бараг нөлөөлөөгүй. Сануулгыг олон нийтийн сүлжээнд тавиагүйгээс гадна дараа нь эдгээр мэдээллийн хэрэгслүүдийн аль нь ч редакцын бодлогодоо өөрчлөлт оруулаагүй. СЕХ нь хэвлэл мэдээлэлтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх, мөн сонгуулийн сурталчилгаатай холбоотой хуулийн заалтуудыг мэдээллийн хэрэгслүүд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих зорилготой Хэвлэл мэдээллийн тусгай зөвлөлийг байгуулсангүй.

## Өргөдөл гомдол

Иргэн, хуулийн этгээд нь сонгуулийн үйл явцад хамаарах аливаа шийдвэр, үйл ажиллагааны талаар өргөдөл гомдол гаргах эрхтэй байдаг. Сонгуулийн хороодын үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй)-ны улмаас эрх нь зөрчигдсэн гэж үзвэл өргөдлөө тухайн сонгуулийн хороонд гаргаж, гаргасан шийдвэр нь дээд шатны хороонд давж заалдах боломжтой. СЕХ-ны шийдвэрийг эхлээд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд анхан шатны журмаар гаргах ба цаашлаад Дээд шүүхэд хандана. СЕХ-оос гарч буй шийдвэрүүд, үүний дотор сонгуулийн дүнтэй холбогдуулан Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэж болдог.

Нэхэмжлэл гаргагч нь сонгуулийн байгууллагын маргаантай шийдвэр гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор нэхэмжлэл гаргах эрхтэй. Захиргааны хэргийн шүүх 40 хоногийн хугацаанд, Дээд шүүх нь 21 хоногийн хугацаанд сонгуультай холбоотой хэргүүд дээр шийдвэр гаргана. Шийдвэр гаргах эцсийн хугацаа нь хэтэрхий урт, мөн хуулиар хамгаалуулах эрхийг хязгаарлаж

<sup>42</sup> МАН-ын нэр дэвшигчид зориулж сонгосон асуултуудаас дурдвал: “Таныг аядуу тайван хүн гэдэг. Улс төрд таны унаган зан арай зөөлддөг гэж боддоггүй юу?” “Таны эхнэр өндөр боловсролтой багш хүн. Та ханьтайгаа хаана танилцсан бэ?”

<sup>43</sup> Мониторинг хийгдсэн хэвлэл мэдээллийн хэрэгслээс, АН төлбөртэй сурталчилгааны 39 хувийг худалдаж авсан, МАН 37 хувийг авсан бол, МАХН 24 хувийг авчээ. МАН мониторинг хийгдсэн дөрвөн телевизийн алинаас нь ч төлбөртэй сурталчилгааны цаг аваагүй (С1), харин МАХН-ын сурталчилгаа хоёр телевиз (С1, Ийгл ньос)-ээр гараагүй.

байна.<sup>44</sup> Гэсэн хэдий ч, шүүх сонгууль болохоос өмнөх хугацаанд сонгуультай холбоотой хэргүүдийг хуульд заасан эцсийн хугацаанд тулгахгүйгээр шийдвэрлэхийг чармайж байв. Үндсэн хуулийн цэцэд шийдвэр гаргахтай холбоотой тодорхой заасан эцсийн хугацаа байдаггүй.

СЕХ-ны хоёр шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргасан ч эл хоёр хэргийг хэрэгсэхгүй болгосон. АНСХ болон СДСХ-дтой холбогдох хэд хэдэн гомдол гаргасан нь ихэнхдээ сонгуулийн байгууллагын бүрэлдэхүүн, санал авах байрны байршил болон сонгуулийн сурталчилгааны зохицуулалттай холбоотой байв.<sup>45</sup>

Сонгуулийн сурталчилгааны үеэр захиргааны ба эрүүгийн хэргүүдийг эхлээд цагдаагийн газраас шалгаж тогтоогоод, доод шатны шүүхээр хянан шалгуулдаг. Санал авах өдрөөс өмнө цагдаагийн байгууллалгад сонгуулийн сурталчилгаатай холбоотой 500 орчим гомдол ирснээс тэр дундаа зурагт самбарыг сүйтгэсэн, нэр дэвшигчдийг гутаан доромжилсон, мөн санал худалдан авах гэж байна гэсэн гомдлууд иржээ.<sup>46</sup>

Хууль бус санхүүгийн ажиллагаатай холбоотой цагдаагийн байгууллагад ирсэн хоёр томоохон хэрэг сонгуулийн өмнөх орчинд нөлөөлсөн. Хуулиар хориглосон байдаг ч гадаадын шашны байгууллагаас сонгуулийн сурталчилгааны хандив авсан гэх үндэслэлээр нэгэн иргэн СЕХ-нд гомдол гаргаснаар МАХН-аас нэр дэвшигчийн нэр дэвших эрхийг сонгууль болохоос гуравхан хоногийн өмнө хөндөв.<sup>47</sup> 6-р сарын 24-ний өдөр цагдаагийн байгууллага 1.08 тэрбум төгрөгийн бэлэн мөнгийг хураан авсан өөр нэг хэрэг гарсан, энэ мөнгөөр АН-ын нэрийн өмнөөс сонгогчдыг хахуулдах гэж байсан тухай цагдаагийн газраас мэдээлсэн.<sup>48</sup> Энэхүү хоёр хэргийг цагдаагийн газар түргэн зохицуулсан ч, сонгууль болохоос өмнө ямар нэг шийдвэр гарсангүй.<sup>49</sup> АН болон МАХН-аас ажиглагчидтай уулзаж ярилцсан хүмүүс цагдаагийн байгууллага эдгээр хэргийн талаар олон нийтэд мэдэгдсэнд санаа зовниж буйгаа илэрхийлж байсан бөгөөд МАХН-тай холбоотой хэрэг дээр шүүхээр нотлогдоогүй байхад СЕХ нэр дэвшигчдэд нь шударга бус хандсан гэж байв.

<sup>44</sup> [1990 оны ЕАБХАБ-ын Копенгагены баримт бичгийн](#) 5.10-р зүйлд “үндсэн эрхийг хүндэтгэж, эрх зүйн бүрэн бүтэн байдлыг хангах үүднээс хүн бүр захиргааны шийдвэрийн эсрэг залруулах үр дүнтэй арга хэрэгслүүдийн эрхтэй байх болно” гэж заажээ.

<sup>45</sup> СЕХ доод шатны сонгуулийн хороодод ирсэн нийт өргөдөл гомдлыг нэгтгэж улс орон даяар мэдээлдгүйгээс болж, өргөдөл гомдлын нийт тоо, агуулга, өргөдөл гомдлын талаарх шийдвэр олон нийтэд ил тод байсангүй.

<sup>46</sup> Нийт хэргийн ойролцоогоор 65 хувийг нь шүүхэд хэлэлцүүлэхээр оруулж эсвэл хэрэгсэхгүй болгосон байна.

<sup>47</sup> 2017 оны 6-р сарын 16-ны өдөр олон нийтийн цахим хэрэгслээр МАХН-аас нэр дэвшигч 40,000 Америк долларыг гадаадын шашны байгууллагаас авж буй мэт харуулсан бичлэг ил гарсан. Энэ бичлэгийг нэр дэвшигчийн гэрт 2017 оны 5-р сарын 23-нд хийсэн байсан. Тус бичлэгийг дараа нь МАН-аас төлбөр төлөн телевизүүдээр гаргуулсан. 6-р сарын 21-ний өдөр СЕХ-нд гаргасан өргөдөл нь энэхүү цацагдсан видео бичлэгтэй холбоотой байсан.

<sup>48</sup> 2017 оны 6-р сарын 23-ны өдөр цагдаа Говь-Алтайд нэгэн машиныг зогсооход уг машинд 1.08 тэрбум бэлэн мөнгийг авч явж байсан. Цагдаагийн газраас өгсөн мэдэгдэлд энэ мөнгийг АН санал худалдаж авах зорилгоор баруун аймгууд тээвэрлэсэн гэж мэдэгдсэн. Мөн энэ өдөр, АН-аас таван *аймгийн* 22,000 сонгуулийн ажилтны цалинг төлөх байсан мөнгийг цагдаагийнхан хууль бусаар хураан авсан гэж мэдэгдэл хийсэн.

<sup>49</sup> МАХН-ын нэр дэвшигчийн эсрэг өргөдөл гаргасан өдөр цагдаагийн байгууллага нэр дэвшигчээс мэдүүлэг авалгүйгээр уг видео бичлэгийг үнэн болохыг тодорхойлж мэдэгдэл хийв. Маргааш өглөө нь Баянзүрх дүүргийн шүүх хэргийг мөрдөн байцаалт хангалтгүй гэсэн үндэслэлээр цагдаагийн байгууллагад буцаасан. 6-р сарын 23-ны өдөр цагдаагийн байгууллага хэргийг шүүхэд буцаан шилжүүлсэн. Энэ хэрэг одоогоор хүлээгдэж байна.

## Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.<sup>50</sup> Гэвч зарим төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй сонгогчдын санал өгөх эрхийг эрх зүйн чадамжгүй гэх өргөн хүрээтэй ойлголтод хамаатуулан хязгаарлаж байгаа нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зарчим, үзэл санаанд нийцэхгүй байна. АН болон МАН-аас дэвшиж буй нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгажээ. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-тай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ.<sup>51</sup>

СТХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно. Түүнчлэн санал авах байруудыг харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Олон улсын ажиглагчдын хорооны очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдсөн байсан. Хэдийгээр СТХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв. Хөгжлийн бэрхшээлтэй олон иргэд сонгуулийн өмнөх өдөр зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгсөн. Зөөврийн хайрцгаар санал хураасан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд саналаа өгөх боломжийг олгосон хэдий ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй.<sup>52</sup>

## Иргэд ба Олон улсын ажиглалт

Дотоод, гадаадын ба олон улсын байгууллагууд, мөн нэр дэвшигчээ дэвшүүлж буй намууд сонгуулийн ажиглагч томилж болно. Хууль эрх зүйн хүрээнд бүх ажиглагчдад холбогдох эрхийг хангалттай хэмжээнд олгосон байдаг.<sup>53</sup> СЕХ нь зургаан ИНБ, нэр дэвшигч дэвшүүлсэн улс төрийн намуудын 17,947 ажиглагчийг бүртгэж, үнэмлэх олгожээ.

<sup>50</sup> 2009 оноос хойш Монгол Улс нь [НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид](#) (ХБХЭК) нэгдэн орсон. Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхахыг зөвхөн ерөнхий зарчмаар хангаж, харин баталгаатай арга хэмжээгээр зааварчлаагүй байдаг. 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар болон бусад холбогдох хуулийн заалтуудаар улс төрийн оролцоонд хамаарах зохих хамгаалалт, нөхцөлөөр ханган өгсөн.

<sup>51</sup> Жишээлбэл, Баянзүрх дүүрэгт болсон АН-аас ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны үеэр.

<sup>52</sup> Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас барагцаалж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж санал өгснөөс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхийг хүсчээ. [ХБХЭК-ийн 29-р зүйлд улс орнуудад](#) “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”-ыг зөвлөсөн байдаг. Мөн [Хөгжлийн бэрхшээлтэй иргэд сонгуульд оролцох тухай Сонгуультай холбоотой Сайн туршлагын дүрмийн талаар тайлбарласан Венецийн комиссын шинэчилсэн тунхаглал](#)-ыг үзнэ үү.

<sup>53</sup> Ажиглагчдын эдлэх эрх нь дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах, санал тооллогын дүнгийн хуулбар, бөглөгдсөн саналын хуудасны зурган дүрсийг хуулбарлан авах зэргээр тусгагджээ.

Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээ нь санал авах өдрөөс өмнөх хугацаанд хэвлэл мэдээлэл, сонгуулийн сурталчилгааны зардал болон санал тоолох электрон төхөөрөмжийн бэлтгэл ажилд мониторинг хийсэн.<sup>54</sup> Тус сүлжээ нь сонгууль болохын өмнөхөн санал тоолох төхөөрөмж болон СЕХ-ны сервер дээр нэмэлт, хараат бус хяналт шалгалтыг мөн явуулсан. Энэхүү сүлжээний гишүүн байгууллагууд нь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн нөлөөлөлд автсан тухай, сонгуулийн сурталчилгааны зардал ил тод бус, саналын машины үнэн зөв, аюулгүй байдал, СЕХ-ны серверийн талаар онцлон тэмдэглэсэн мэдээллийг тогтмол гаргаж байсан. Нийслэл хотоос өөр газар буй цөөн тооны ИНБ сонгогчдын боловсролд чиглэсэн хөтөлбөрүүдээс гадна сонгуультай холбоотой үйл ажиллагаанд идэвхтэй оролцжээ. ИНБ-ууд сонгуулийн өдөр нарийвчилсан байдлаар ажиглалт хийгээгүй ч, Улаанбаатар хотын 50 гаруй санал авах байруудад сүлжээний ажиглагчдаа ажиллуулсан.

### Сонгуулийн өдөр

Ажиглалт хийгдсэн ихэнх санал авах байранд сонгууль эмх журамтай явагдаж, сонгуулийн хэсгийн хороодын ажилтнууд санал хураалтыг тогтоосон журмын дагуу ажиллав. ОУСАХ-ны ажиглахаар очсон бүх санал авах байруудад эмэгтэй ажилтнууд эрэгтэйчүүдээс тоогор илүү байсан. Ажиглалт хийсэн бүх санал авах байранд намуудын ажиглагчид байсан бол, иргэд олон нийтийн ажиглагчдын төлөөлөл зөвхөн нийслэлийн цөөн хэдэн газарт ажилласан. Цагдаагийн байгууллагад сонгуулийн өдөр 150 орчим өргөдөл гомдол ирснээс 86 нь санал худалдаж авсан гэх гомдлууд байлаа. Сонгуулийн өдөр АН болон МАХН-аас сонгогчдын саналыг худалдан авах гэсэн хууль бус тохиолдлуудын талаар олон нийтэд мэдэгдэл хийсэн.

Санал авах байруудын нээлт дээр ямар нэг ноцтой саатал гарсан тухай мэдэгдээгүй бөгөөд шаардлагатай бүх материал, эд хэрэгсэл байсан. Улаанбаатар хотын сонгогчдод хурууны тэмдэглэгээ хийх талаар сүүлийн мөчид гаргасан шийдвэрийг эс тооцвол санал хураалт явуулах тухай СЕХ-ны зааварчилгаа тогтмол хэрэгжиж байв.<sup>55</sup> Сонгогчдын биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийн мэдээлэл болон СТТ-д ямар нэгэн ноцтой зөрчил гарсан гэж мэдэгдээгүй.<sup>56</sup> Хэдийгээр сонгогчдод саналаа нууцаар өгөхөд зориулсан нууцлалын хавтас өгсөн нь сайшаалтай хэрэг байсан боловч хэд хэдэн санал авах байранд төөрөгдөл үүсэж, саналын нууцлалт нэг түвшинд мөрдөгдөх нөхцөл хангагдсангүй. Үүний улмаас саналын нууцлал зарим үед алдагдаж байлаа.

ОУСАХ-ны очсон санал авах байрууд цагтаа хаагдаж, СТТ-өөр саналын дүнг нэгтгэн гаргасан. СЕХ-ны шийдвэрээр хуульд заасан хамгийн дээд хувь руу ойртуулан, санал авах байрны 50 орчим хувийг санамсаргүй сонголтын аргаар сонгож, техникийн тооллогыг хийсэн. Техникийн тооллогыг шууд, зарим газар ялихгүй хугацааны дараа эхлүүлж байлаа. ОУСАХ-ны ажигласан техникийн тооллогын дийлэнх нь хурдан шуурхай явагдаж байсан ба цөөн тооны тооллого дээр зохион байгуулалт сул байв. ОУСАХ-ны ажиглагчдыг дийлэнх санал авах байруудад найрсгаар хүлээн авч байсан, харин нэг санал авах байр дээр ажиглагчдын нэг багт саналын дүн тоолох явцыг ажиглахыг зөвшөөрөөгүй бол, бас нэг багийг нэгэн АНСХ-ны үйл ажиллагааг ажиглах гэхэд оруулаагүй байна.

Санал авах байрууд автомат тооллого хийгдэж дуусмагц санал хураалтын дүнг СЕХ руу тэр

<sup>54</sup> Сүлжээний гишүүн байгууллагуудад Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшнл, МИДАС, Өөрчлөлтийн төлөөх Эмэгтэйчүүд ТББ, Захиргааны шинэ санаачлага, Бодлогод залуусын хяналт ТББ орж байна.

<sup>55</sup> АН-аас тавьсан хүсэлтийн хариуд СЕХ нь 6-р сарын 23-ны өдөр Улаанбаатар хотод байрлаж буй нийт 403 хэсгийн хороонд арилдаггүй бэхийг хүргүүлэв. ОУСАХ-ны очсон бүх санал авах байр дээр бүгд сонгогчдын хуруунд тэмдэглэгээг хийж байлаа.

<sup>56</sup> СЕХ болон АНСХ дээр очсон ОУСАХ-ны ажиглагчид биометрийн мэдээллийг унших төхөөрөмж болон СТТ-тэй холбоотой техникийн асуудлууд алс хөдөө орон нутагт гарсан тухай мэдээлсэн.

дарууд нь цахимаар дамжуулж байв. Гадаад улсад байгаа иргэдийн санал тоолох ажиллагааг санал авах шөнө санал хураалт дуусмагц СЕХ-ны байран дээр ажиглагчдыг байлцуулан явуулсан.<sup>57</sup> СЕХ нь санал хураалтын дүнг урьдчилсан байдлаар шууд дамжуулж байсан нь ил тод байдлыг ерөнхийд нь нэмэгдүүлж байв. Гэвч СЕХ-ны цахим хуудас дээр санал хураалтын дүнг сум, хэсгийн хороодын аль нэгээр задаргаа хийж харуулаагүй нь бие даасан хяналт тавих боломжийг хязгаарласан явдал болов. СЕХ-ноос сонгуулийн ирц 68.27 хувьтай гэж мэдэгдэв.

*Энэхүү тайлангийн Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны хувь болно.  
Монгол хэл дээрх албан бус орчуулгыг авах боломжтой.*

---

## ХОРООНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ БОЛОН ТАЛАРХАЛ

---

Улаанбаатар хот, 2017 оны 6-р сарын 27 – Энэхүү Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан нь ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар (ЕАБХАБ-ын АИХЭГ), ЕАБХАБ-ын Парламентын ассемблей (ЕАБХАБ-ын ПА) болон Европын парламент (ЕП)-ын хамтарсан үйл ажиллагааны үр дүн юм. Сонгуулийн ажиглалт үнэлгээг энэ удаагийн сонгууль ЕАБХАБ-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд, ардчилсан сонгуультай холбогдох бусад олон улсын үүрэг, хэм хэмжээ болон дотоодын хууль тогтоомжуудтай нийцэж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор хийсэн.

ЕАБХАБ-ын Тусгай зохицуулагч, богино хугацааны ажиглагчдын багийн удирдагчаар Гиблиелмо Пики (Итали) ажилласан бөгөөд түүнийг ЕАБХАБ-ын дарга улсаас томилсон. ЕАБХАБ-ын Парламентын ассемблейн төлөөлөгчдийн тэргүүнээр Георгиос Варменос (Грек), Европын парламентын төлөөлөгчдийн тэргүүнээр Лайма Андрикиене (Литви) нар ажиллав. 5-р сарын 22-ны өдөр байгуулагдсан ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны тэргүүнээр элчин сайд Геерт-Хинрич Аренс ажиллав.

Энэхүү Олон улсын сонгуулийг ажиглах хороо (ОУСАХ)-нд хамтран ажилласан байгууллагууд нь 2005 оны Олон улсын сонгуулийг ажиглах зарчмын тунхаглалыг баталсан юм. Энэхүү Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан нь сонгуулийн үйл явц дуусахаас өмнө гарч байна. Энэ удаагийн сонгуулийн талаарх эцсийн үнэлгээ нь сонгуулийн үйл явцын үлдсэн үе шат хэрхэн өрнөх, тухайлбал санал хураалтын дүнг нэгтгэх болон сонгуулийн дараа гарч болзошгүй гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэх зэргээс хамаарна. ЕАБХАБ/АИХЭГ нь сонгуулийн үйл явц дууссанаас хойш найм орчим долоо хоногийн дараа засаж сайжруулах санал зөвлөмжүүдийг багтаасан дэлгэрэнгүй тайланг гаргана. ЕАБХАБ-ын ПА нь өөрийн тайланг 2017 оны 7-р сарын 5-ны өдөр Минск хотноо болох Жилийн эцсийн хуралдааныхаа үеэр Байнгын хороондоо тайлагнана. ЕП-ын Гадаад хэргийн хороо нь хатагтай Андрикиене (ЕПГ)-ний ЕП-ын САХ-ны тайланг удахгүй болох хуралдаан дээрээ авч хэлэлцэнэ.

ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны бүрэлдэхүүнд нийслэл хотод 12 шинжээч, хөдөө орон нутагт ажилласан 20 урт хугацааны ажиглагч багтсан.

Сонгуулийн өдөр нийт 66 ажиглагч ажилласнаас ЕАБХАБ-ын ПА-аас 22 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид, Европын парламентаас 9 парламентын төлөөлөгч оролцлоо. Ажиглагчдыг ЕАБХАБ-ын гишүүн 30 орноос татсан.

Олон улсын ажиглагчдын зүгээс энэ сонгуулийг ажиглах урилга ирүүлсэн Монгол Улсын эрх бүхий байгууллагууд болон туслалцаа үзүүлсэн Сонгуулийн ерөнхий хороонд талархалаа

---

<sup>57</sup> 6-р сарын 10, 11-ны өдрүүдэд гадаадад суугаа сонгогчид дипломат төлөөлөгчдийн газрууд дээрээ саналаа өгцгөөсөн.



**Олон улсын сонгуулийг ажиглах хороо**  
**Монгол Улс, Ерөнхийлөгч сонгууль, 2017 оны 6-р сарын 26-ны өдөр**  
**Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан**

---

илэрхийлж байна. Түүнчлэн хамтран ажилласан бусад төрийн байгууллагууд, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагууд болон олон улсын байгууллагуудын төлөөлөгчдөд талархалаа илэрхийлэхийг хүсэж байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:

- Элчин сайд Гээрт-Хинрич Аренс - Улаанбаатар дахь ЕАБХАБ/АИХЭГ САХХ-ны тэргүүн (+976 77 00 1983);  
Хатагтай Мариа Кучма - ЕАБХАБ/АИХЭГ. Утас: +48 609 038346 Ноён Ульви Ахундлу - ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн зөвлөх. Утас: +48 695 808 813;
- Хатагтай Ирина Сабашук - ЕАБХАБ-ын Парламентын ассемблей, +976 8588 2847, +45 60 108173; [iryana@oscepa.dk](mailto:iryana@oscepa.dk)
- Ноён Филиппе Камарис - ЕАБХАБ-ын Европын парламент, +976 8588 0549, +32 477855267, [philippe.kamaris@ep.europa.eu](mailto:philippe.kamaris@ep.europa.eu)

**ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны хаяг:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 87, 5 давхарт  
Утас: +976 77 00 1983; Факс: 976 77 00 1984  
И-мэйл: [office@odihr.mn](mailto:office@odihr.mn)  
Вэб хуудас: <http://www.osce.org/odihr/elections/mongolia/>